

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-/54/2023-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	
4. Аудитын тайлан	
4.1 Ерөнхий зүйл	
4.2 Материаллаг байдал	
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	
5. Аудитын илрүүлэлт	
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/135
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Н.БАТБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газар Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангаж, Иргэдийн төлөөлөгчдийн Хурал, төсөвт байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр ханган, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцож, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж ажилласан байна. Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилт, хэрэгжүүлэх 46 арга хэмжээтэй баталснаас нийт 86,1 %-тай дүгнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 230,002.9 мянган төгрөгийн барилга байгууламж, 54,450.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 50,545.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,971.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 28,500.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 74,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 55,000.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн

байна. Тайлант онд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 98.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 78,841.5 мянган төгрөг болж 78,742.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Засаг даргын тамгын газрын конторын барилгын өргөтгөлийн санхүүжилт дутуугаас өр үүссэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	86,151,043.81	97,142,393.81
35	БАРАА МАТЕРИАЛ	86,151,043.81	97,142,393.81
354	Хангамжийн материал	71,001,043.81	88,292,393.81
35410	Бичиг хэргийн материал	2,170,260.00	2,221,260.00
35420	Аж ахуйн материал	26,248,518.50	39,840,268.50
35470	Бусад хангамжийн материал	42,582,265.31	46,230,865.31
35600	Мал амьтад	15,150,000.00	8,850,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,447,609,622.49	1,785,775,365.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,447,609,622.49	1,785,775,365.75
392	Биет хөрөнгө	1,360,479,455.90	1,698,905,199.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,416,120,218.62	1,646,123,099.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	-322,568,583.08	-405,281,859.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	133,018,020.00	258,468,020.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-78,436,075.63	-103,407,603.55
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	68,669,899.00	112,175,299.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-28,899,123.39	-39,691,802.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,009,066.17	46,078,110.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,727,473.40	-40,257,876.69
39214	Бусад үндсэн хөрөнгө	313,199,116.00	396,699,116.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-144,905,608.39	-171,999,303.47
393	Биет бус хөрөнгө	87,130,166.59	86,870,166.55
39301	Програм хангамж	1,740,000.00	1,740,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-725,833.41	-985,833.45
39303	Бусад биет бус хөрөнгө	86,116,000.00	86,116,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,533,760,666.30	1,882,917,759.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	98,773.97	78,841,523.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	98,773.97	78,841,523.00
413	Өглөг	98,773.97	78,841,523.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	98,773.97	00.00
4136	Бусад өглөг	00.00	78,841,523.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	78,841,523.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,533,661,892.33	1,804,076,236.56
51	Засгийн газрын хувь оролцоо	1,533,661,892.33	1,804,076,236.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	851,574,968.37	851,574,968.37
51101	Өмч: - төрийн	851,574,968.37	851,574,968.37
512	Хуримтлагдсан үр дүн	270,194,675.66	540,624,931.89
51210	Өмнөх үеийн үр дүн	270,194,675.66	270,210,587.66
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	270,414,344.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	411,892,248.30	411,876,336.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,533,760,666.30	1,882,917,759.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	405,334,701.90	1,055,330,059.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,308,318.00	707,175,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	25,308,318.00	707,175,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,308,318.00	707,175,500.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	530,177,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	25,308,318.00	176,997,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	380,026,383.90	348,154,559.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,726,883.90	14,540,559.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бүс этгээдээс авсан хандив, тусламж	2,208,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,552,738.90	10,671,159.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,966,145.00	3,869,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	343,299,500.00	333,614,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	343,299,500.00	333,614,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	470,684,858.10	742,166,714.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	424,474,069.32	479,399,319.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	423,508,435.99	478,399,319.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	186,245,024.49	197,373,665.86
210101	Үндсэн цалин	136,937,269.85	167,392,886.19
210102	Нэмэгдэл	25,712,837.50	26,482,448.87
210104	Урамшуулал	00.00	3,498,330.80
210105	Гэрээт ажлын хөлс	23,594,917.14	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,164,857.30	23,204,400.03
210201	Тэтгэврийн даатгал	16,734,039.49	16,469,213.15
210202	Тэтгэмжийн даатгал	1,857,762.95	1,760,213.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,486,210.15	1,327,530.92
210204	Ажилгүйдлийн даатгал	371,318.47	328,615.94
210205	Эрүүл мэндийн даатгал	3,715,526.24	3,318,826.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,976,524.00	28,115,900.00
210301	Гэрэл, цахилгаан	4,727,550.00	4,716,926.00
210302	Түлш, халаалт	24,248,974.00	23,398,974.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,145,883.00	31,557,410.00
210401	Бичиг хэрэг	2,022,900.00	1,384,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,713,003.00	28,603,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,309,030.00	1,254,000.00
210404	Ном, хэвлэл	366,200.00	245,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	71,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	161,450.00	00.00
210408	Бараа материал акалсны зардал	9,573,300.00	00.00
2105	Нормативт зардал	00.00	260,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	260,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,400,000.00	3,617,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	150,000.00
210604	Урсгал засвар	6,400,000.00	3,467,450.00
2107	Томилолт, зочны зардал	1,929,500.00	3,073,700.00
210702	Дотоод албан томилолт	1,929,500.00	3,073,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,725,461.00	3,961,576.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	330,366.00	2,612,654.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	280,125.00	236,848.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	356,170.00	367,722.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	139,552.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	137,921,186.20	187,234,417.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,136,112.00	29,031,180.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90,785,074.20	158,203,237.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	965,633.33	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	965,633.33	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	965,633.33	1,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,210,788.78	262,767,395.14
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	191,501,779.00
220001	Барилга байгууламж	00.00	94,290,322.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	13,482,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	83,729,457.00
2260	Гадаад эх үүсвэрээр	46,210,788.78	71,265,616.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-65,350,156.20	313,163,344.23
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	42,749,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	8,750,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	33,999,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-42,749,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-65,350,156.20	270,414,344.23

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	380,026,383.90	878,332,459.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	530,177,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	530,177,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	530,177,900.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	530,177,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	380,026,383.90	348,154,559.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,726,883.90	14,540,559.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,208,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,552,738.90	10,671,159.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,966,145.00	3,869,400.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	343,299,500.00	333,614,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	343,299,500.00	333,614,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	372,526,383.90	392,039,022.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	372,526,383.90	392,039,022.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,355,595.12	319,773,405.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	185,897,031.49	179,877,368.83
210101	Үндсэн цалин	133,747,487.29	151,108,458.47
210102	Нэмэгдэл	26,120,807.13	25,040,761.94
210104	Урамшуулал	00.00	3,498,330.80
210105	Гэрээт ажлын хөлс	26,028,737.07	229,817.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,107,387.30	23,664,562.03
210201	Тэтгэврийн даатгал	16,676,569.49	16,441,827.50
210202	Тэтгэмжийн даатгал	1,857,762.95	1,891,550.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,486,210.15	1,422,520.42
210204	Ажилгүйдлийн даатгал	371,318.47	352,363.32
210205	Эрүүл мэндийн даатгал	3,715,526.24	3,556,300.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,565,900.00	28,565,900.00
210301	Гэрэл, цахилгаан	4,716,926.00	4,716,926.00
210302	Түлш, халаалт	23,848,974.00	23,848,974.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,798,755.00	28,292,350.00
210401	Бичиг хэрэг	2,266,466.00	1,435,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,340,940.00	22,088,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,311,254.00	1,324,000.00
210404	Ном, хэвлэл	680,095.00	245,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	3,200,000.00
2105	Нормативт зардал	199,083.33	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	199,083.33	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,400,000.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	6,400,000.00	6,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,929,500.00	2,773,700.00
210702	Дотоод албан томилолт	1,929,500.00	2,773,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,236,834.00	19,425,707.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	869,634.00	18,076,785.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	288,400.00	288,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,000.00	316,170.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	139,552.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,221,104.00	30,573,818.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,117,104.00	30,573,818.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,170,788.78	72,265,616.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	960,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	960,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,210,788.78	71,265,616.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,210,788.78	71,265,616.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,500,000.00	486,293,437.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,500,000.00	486,293,437.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,500,000.00	486,293,437.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,500,000.00	486,293,437.00
220001	Барилга байгууламж	00.00	245,451,680.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	131,867,100.00
223001	Бусад хөрөнгө	00.00	108,974,657.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,500,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-7,500,000.00	-486,293,437.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	851,574,968.37	411,892,248.30	294,126,591.76	00.00	1,557,593,808.43
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	851,574,968.37	411,892,248.30	294,126,591.76	00.00	1,557,593,808.43
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	41,418,240.10	00.00	41,418,240.10
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	851,574,968.37	411,892,248.30	270,194,675.66	00.00	1,533,661,892.33
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	851,574,968.37	411,892,248.30	270,194,675.66	00.00	1,533,661,892.33
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	15,912.00	00.00	15,912.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	851,574,968.37	411,892,248.30	270,210,587.66	00.00	1,533,677,804.33
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-15,912.00	00.00	00.00	-15,912.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	270,414,344.23	00.00	270,414,344.23
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	851,574,968.37	411,876,336.30	540,624,931.89	00.00	1,804,076,236.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	332,604,700.00	377,498,463.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	332,604,700.00	377,498,463.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	331,604,700.00	312,968,045.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,985,400.00	179,877,368.83
210101	Үндсэн цалин	163,428,400.00	151,108,458.47
210102	Нэмэгдэл	27,557,000.00	25,040,761.94
210104	Урамшуулал	-	3,498,330.80
210105	Гэрээт ажлын хөлс	-	229,817.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,916,700.00	23,664,562.03
210201	Тэтгэврийн даатгал	17,193,900.00	16,441,827.50
210202	Тэтгэмжийн даатгал	1,910,800.00	1,891,550.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,528,500.00	1,422,520.42
210204	Ажилгүйдлийн даатгал	382,200.00	352,363.32
210205	Эрүүл мэндийн даатгал	3,901,300.00	3,556,300.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,565,900.00	28,565,900.00
210301	Гэрэл, цахилгаан	4,571,900.00	4,716,926.00
210302	Түлш, халаалт	23,874,000.00	23,848,974.00
210303	Цэвэр, бохир ус	120,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	27,290,400.00	27,259,600.00
210401	Бичиг хэрэг	928,800.00	1,435,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,055,600.00	21,055,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,506,000.00	1,324,000.00
210404	Ном, хэвлэл	600,000.00	245,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	3,200,000.00
2105	Нормативт зардал	450,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	6,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,824,600.00	2,773,700.00
210702	Дотоод албан томилолт	2,824,600.00	2,773,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,571,700.00	19,425,707.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,204,500.00	18,076,785.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	288,400.00	288,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,000.00	316,170.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	139,552.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,000,000.00	24,801,208.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,000,000.00	24,801,208.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	530,177,900.00	486,293,437.00
2200	Дотоод эх үүсвэрээр	530,177,900.00	486,293,437.00
220001	Барилга байгууламж	255,171,800.00	245,451,680.00
222001	Тоног төхөөрөмж	128,052,000.00	131,867,100.00
223001	Бусад хөрөнгө	146,954,100.00	108,974,657.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	863,791,900.00	800,261,482.86
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	333,614,000.00	313,968,045.86
132001	Орон нутгийн төсвөөс	333,614,000.00	313,968,045.86
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	530,177,900.00	486,293,437.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	530,177,900.00	486,293,437.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01
610001	Төсвийн байгууллага	01	01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	21
620001	Удирдах ажилтан	03	03
620002	Гүйцэтгэх ажилтан	11	10
620003	Үйлчлэх ажилтан	08	08

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,726,883.90	14,540,559.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,081,634.00	6,805,360.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,081,634.00	6,805,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,032,750.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,032,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	869,634.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	869,634.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,212,000.00	5,772,610.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,108,000.00	5,772,610.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,645,249.90	7,735,199.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	4,645,249.90	7,735,199.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	36,726,883.90	14,540,559.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,726,883.90	14,540,559.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,208,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,518,883.90	14,540,559.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газар нь төрийн үйлчилгээг иргэдэд тасралтгүй, түргэн шуурхай, чанартай үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг, хууль тогтоомж, төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн сумынхаа хөгжил цэцэглэлтийн төлөө сэтгэл зүрхээ зориулан ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, шадар туслагч нь байхад оршино гэсэн зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газар Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангаж, Иргэдийн төлөөлөгчдийн Хурал, төсөвт байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр ханган, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцож, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн А/01 тушаалаар тушаалаар бүтэц орон тоо 25 байхаар баталж үйл ажиллагааг явуулж ажилласан байна. Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилт, хэрэгжүүлэх 46 арга хэмжээтэй баталснаас нийт 86,1 %-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 4 дүгээр сарын 29-ний, 2022 оны 7 дугаар сарын 01-ний, 2022 оны 8 дугаар сарын 29-ний, 2022 оны 12 дугаар сарын 9-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой зарим заалтад 4 дүгээр сарын 29-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн "Дотоод хяналт, шалгалтын баг шинэчлэн батлах тухай" А/02 тушаалаар томилж Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналт шалгалтын комисс нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 7 арга хэмжээг улирлаар төлөвлөн хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Тус байгууллагад тайлант онд аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас санхүүгийн баримтад хяналт шалгалт хийгээгүй байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газар 2013 онд батлагдсан 4 бүлэг 71 зүйлтэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 349,157.0 мянган төгрөгөөр буюу 22,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал	86,151.1	97,142.4	10,991.3
Үндсэн хөрөнгө	1,447,609.6	1,785,775.3	338,165.7
Нийт хөрөнгө	1,533,760.7	1,882,917.7	349,157.0
Өр төлбөр	98.8	78,841.5	78,742.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,533,661.9	1,804,076.2	270,414.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,533,760.7	1,882,917.7	349,157.0

Дээрх хүснэгтээс харахад: Бараа материал дансны эхний үлдэгдэл 86,151.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 97,142.4 мянган төгрөг буюу худалдан авсан хөрөнгө 10,991.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,447,609.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,789,481.2 мянган төгрөг болж, 341,841.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 368,469.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 129,000.0 мянган төгрөг байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 230,002.9 мянган төгрөгийн барилга байгууламж, 54,450.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 50,545.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,971.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 28,500.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 74,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 55,000.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Тайлант онд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 98.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 78,841.5 мянган төгрөг болж 78,742.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Засаг даргын тамгын газрын конторын барилгын өргөтгөлийн санхүүжилт дутуугаас өр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,807,782.1 мянган төгрөг болж 274,120.2 төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 348,948.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас Төв аймгийн Баян-Өнжүүл сумын сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны зардлыг 330,280.0 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтын зардалд 450,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 780,280.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор үйл ажиллагааны зардлыг 3,334.0 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг 80,177.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 863,791.9 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 863,791.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн үйл ажиллагааны орлого 12,821.2 мянган төгрөг, гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардал 4,326.5 мянган төгрөг, баг, хорооны үйл ажиллагааны зардал 290.4 мянган төгрөг, бусад зардлаас 43,884.5 мянган төгрөг, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 2,207.9 мянган төгрөг нийт 63,530.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 800,261.4 мянган төгрөг буюу 92,6 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын төсвийг 19,646.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 43,884.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-үндсэн үйл ажиллагааны зардал	232,655.8	219,834.6	12,821.2	94.5
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ	29,799.0	25,472.5	4,326.5	85.5
3	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-баг хорооны үйл ажиллагааны зардал	41,959.2	41,668.8	290.4	99.3
4	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,000.0	1,000.0	0.0	100.0
5	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-бусад хөрөнгийн зардал	530,177.9	486,293.4	43,884.5	91.7

6	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	5,000.0	0.0	100.0
7	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Улсын их баяр наадмын зардал	5,000.0	5,000.0	0.0	100.0
8	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	15,000.0	12,792.1	2,207.9	85.3
9	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Хур хог хаягдал, орчны бохирдлын зардал	3,200.0	3,200.0	0.0	100.0
	Дүн	863,791.9	800,261.4	63,530.5	92.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд өвс тэжээлийн үнэ 3,869.4 мянган төгрөг, ажил зуучлалын зардал 66.0 мянган төгрөг, урьд оны санхүүжилтээс 4,645.2 мянган төгрөг, малын гоц халдварт өвчний зардал 1,239.3 мянган төгрөг, тендерийн төлбөр 540.0 мянган төгрөг, хөдөө аж ахуйн тооллогын зардал 1,582.6 мянган төгрөг, санхүүжилт 2,478.0 мянган төгрөг, лицензийн төлбөр нийт 14,540.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар ажил зуучлалын зардалд 66.0 мянган төгрөг хөдөө аж ахуйн тооллогын зардал 3,290.8 мянган төгрөг, шагналд 2,415.8 мянган төгрөг, малын гоц халдварт өвчний зардал 1,032.7 мянган төгрөг нийт 6,805.3 мянган төгрөг зарцуулж 7,735.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 92,6%	863,791.9	800,261.4

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шилэн данс, шатахууны тооцоо бодолт, төсвийн зарцуулалттай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны батлагдсан 863,791.9 мянган төгрөгийн зардлаас 1,0 хувиар буюу 8,637.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,046.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 83,9 хувь, 5,0 саяас дээших орлогын 18 гүйлгээ, зарлагын 24 гүйлгээ байршуулахаас 381,561.4 мянган төгрөгийн 10 зарлагын гүйлгээ байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийг зориулалт бусаар зарцуулсантай холбоотой 3 төлбөрийн акт, цахим төлбөрийн баримттай холбоотой 1 албан шаардлага, зориулалт бус зарцуулалт, нягтлан бодох бүртгэлийн тайлагнал, шилэн данстай холбоотой 4 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 02/36 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	1,712.9	3	1,712.9	100
Албан шаардлага	1	29,189.9	1	29,189.9	100
Зөвлөмж	4	25,173.8	4	25,173.8	100
Нийт дүн	8	56,076.6	8	56,076.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад дараагийн аудитаар анхаарах, авч үзэх асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 310,844.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 310,844. мянган төгрөгийн алдааг залрууллаа.

1. Санхүүгийн тайланд Засаг даргын тамгын газрын өргөтгөлийн барилгын үлдэгдэл санхүүжилт 78,841.5 мянган төгрөгийг өглөгөөр тусгаж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.Тус байгууллага тайлант онд санхүүгийн тайланд Засаг даргын тамгын газрын 232,002.9 мянган төгрөгийн өргөтгөлийн барилга хүлээн авсныг тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 410,464.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 410,464.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

5.4 Зөвлөмж

Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд нийтийн эдэлбэр газрын хог цэвэрлэхэд сурагчдад 300.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах.

2. Тус байгууллага тайлант онд шаардах хуудас, замын хуудас, шатахуун талон олгох зөвшөөрлийн бичгээр 28,603.4 мянган төгрөг зарцуулж, жолоочийн тооцоо бодоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахуун олгохдоо жолоочийн тооцооны хуудсаар тооцоо бодож байх.

3. Тус байгууллага тайлант онд шилэн дансанд 5,0 саяас дээших зарлагын 381,561.4 мянган төгрөгийн 10 гүйлгээ байршуулаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд ЗДТГ-ын өргөтгөлийн барилгын үлдэгдэл санхүүжилт өглөгөөр тусгаж тайлагнаагүй байна	1	78,841.5	1	78,841.5			1	78,841.5		
Санхүүгийн тайланд Засаг даргын тамгын газрын өргөтгөлийн барилга хүлээн авсныг тайлагнаагүй байна	1	232,002.9	1	232,002.9			1	232,002.9		
Дүн	2	310,844.4	2	310,844.4			2	310,844.4		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийтийн эдэлбэр газрын хог цэвэрлэхэд сурагчдад урамшуулал олгосон	1	300.0					1	300.0
Шатахууны тайлан гаргахдаа жолоочийн тооцоо бодоогүй байна.	1	28,603.4					1	28,603.4
Дүн	2	28,903.4					2	28,903.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил				
Тус байгууллага тайлант онд шилэн дансанд 5,0 саяас дээших зарлагын 10 гүйлгээ байршуулаагүй байна	1	381,561.4	1	381,561.4
Дүн	1	381,561.4	1	381,561.4
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил				
Дүн				
Нийт дүн	1	381,561.4	1	381,561.4

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn